

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 4 дүгээр
сарын 29-ний өдрийн A/05 дугаар Цийдвэрийн Хавсралт I

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР

9010 002004 -дугаарт

БҮРТГЭВ

2024.07.18 -өдөр

УЛСЫН БҮРТГЭГЧ 411

ИНВЕСКОР БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- “Инвекор ББСБ” (Банк бус санхүүгийн байгууллага) ХК (цаашид “Компани” гэх) нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасны дагуу ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор нээлттэй буюу хувьцаат компанийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд юм.
- Энэхүү Дүрмийн зорилт нь Компанийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, дотоод үйл ажиллагаатай холбоотойгоор өөрчлөн зохион байгуулах, Компанийн удирдлага, зохион байгуулалт тэдгээрийн чиг үүрэг, үйл ажиллагааны үндсэн зарчим, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчийн бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоо, Дүрмийн 9.1 дэх хэсэгт заасан төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хурлын бүрэн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоо болон Компанийг татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- Компанийн Дүрэм нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн акттай харшлах, зөрчилдөх тохиолдолд Компани нь холбогдох хууль тогтоомжийн актад нийцүүлэн энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэгтэй байна.

2. КОМПАНИЙН ОНООСОН НЭР, ОРШИН БАЙГАА ГАЗАР

- Компанийн оноосон нэрийг "ИНВЕСКОР ББСБ" ХК, англиар INVESCORE NBFI /Non Banking Financial Institution/ Joint Stock Company гэнэ. Компани нь хувьцаат компани буюу “ХК” хэлбэртэй байна.
- Компани хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд “ХК” гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.
- Компанийн ерөнхий захиргаа, удирдлага нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол /14320/, Парисын гудамж, 42-р байр, 1401 тоот болон 1402 тоот хаягт оршин байрлана.

3. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- Компани нь Зөвшөөрлийн тухай хууль болон Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос зохих зөвшөөрлийг авсны үндсэн дээр дараах үндсэн аж ахуйн үйл ажиллагаануудыг эрхлэн явуулна. Үүнд:
 - Зээлийн үйл ажиллагаа;
 - Факторингийн үйлчилгээ үзүүлэх;
 - Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт оруулах;
 - Итгэлцлийн үйлчилгээ;
 - Төлбөрийн баталгаа гаргах;

- 3.2. Компани нь Компанийн тухай хууль, Иргэний хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомж, Дүрэмд заасны дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 3.3. Компани нь ТУЗ болон холбогдох хууль тогтоомжийн актад заасан бусад үндэслэлээр Компанийн үйл ажиллагааг дуусгавар болгох хүртэлх хугацаанд үйл ажиллагаагаа хугацаагүй эрхлэн явуулна. Тусгай зөвшөөрөлтэйгөөр явуулах үйл ажиллагааны хугацаа нь хуулийн дагуу тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацаагаар тодорхойлогдоно.
- 3.4. Дүрмийн 3.1 дэх хэсэгт заагаагүй бусад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх асуудлыг ТУЗ шийдвэрлэх бөгөөд холбогдох төрийн байгууллагуудаас зөвшөөрөл авч бүртгүүлснээр үйл ажиллагааг эрхлэн явуулна.

4. КОМПАНИЙН ЭРХ ХЭМЖЭЭ

- 4.1. Компанийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэн Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрийг Компани үүсгэн байгуулагдсан өдөр гэж тооцно.
- 4.2. Компани үүсгэн байгуулагдсан өдрөөс эхлэн хувьцаа Эзэмшигчээс тусгайлан өмчилсөн өөрийн эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх олж, үүрэг хүлээх, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг өөрийн эд хөрөнгийн хэмжээгээр хариуцах, шүүх, арбитрт өөрийн нэрийн өмнөөс оролцох эрхийн чадвартай, банкинд өөрийн нэр бүхий данстай, бие даасан тайлан баланстай, Дүрэмд заасан үйл ажиллагаа явуулах эрх зүйн чадвартай байна.
- 4.3. Компанийн эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээс бүрдэх бөгөөд Компани нь хүлээсэн үүргээ өөрийн өмчлөлд байгаа бүх эд хөрөнгөөрөө хариуцах ба хувьцаа Эзэмшигчдийн өр болон хүлээх үүргийг хариуцахгүй.
- 4.4. Хувьцаа Эзэмшигч нь Компанид оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийнхөө хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээх бөгөөд Компанийн хүлээх эрх, үүрэг, өр, төлбөр шаардах эрхийг хариуцахгүй.
- 4.5. Компани нь Монгол Улсад болон гадаад улсад өөрийн хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрыг Компанийн тухай хуулийн дагуу байгуулах эрхтэй байна. Хараат болон охин компани нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэх бөгөөд тэдгээр нь эрх бүхий байгууллагаас баталсан дүрмийн дагуу бие дааж үйл ажиллагаагаа явуулна. Салбар болон төлөөлөгчийн газар нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэхгүй бөгөөд Компанийн баталсан журмын дагуу үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.
- 4.6. Компани нь өөрийн тамга, тэмдэг, барааны тэмдэг (лого), албан бичгийн хэвлэмэл хуудастай байна. Гүйцэтгэх Захирал нь Компанийн тамга, тэмдэг ашиглах аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. Аливаа албан бичгэн дээр дарагдах Компанийн тамга, тэмдэг нь эрх бүхий этгээд, Гүйцэтгэх Захирал эсхүл тэдгээрийн эрх олгосон этгээдийн гарын үсгээр баталгаажигдаж гэрчлэгдэнэ.
- 4.7. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан зөвшөөрлийг үндэслэн, салбар, төлөөлөгчийн газар байгуулж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь тусдаа улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга, тэмдэг, үйл ажиллагааны журамтай байна.



5. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА

- 5.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь Компанийн нийт гаргасан бөгөөд эргэлтэд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөнд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.
- 5.2. Компанийн зарласан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 82,000,000 (наян хоёр сая) ширхэг байна.
- 5.3. Компанийн гаргасан энгийн хувьцааны тоо нь нэг бүр нь 227 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 75,744,281 (далан таван сая долоон зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун наян нэгэн) ширхэг байна.
- 5.4. Компанийн гаргасан давуу эрхийн хувьцааны тоо нь нэг бүр нь 5,000 (Таван мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,400,000 (Хоёр сая дөрвөн зуун мянган) ширхэг байна.
- 5.5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нийт 29,193,951,787 (Хорин есөн тэрбум нэг зуун ерэн гурван сая есөн зуун тавин нэгэн мянга долоон зуун наян долоон) төгрөг байна.
- 5.6. Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллана.
- 5.7. Компани нь давуу эрхийн хувьцаа гаргаж болно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх зэргийг тухай бүр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 5.8. Гаргасан хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох бөгөөд энэ тохиолдолд хувьцааны төлбөрт хүлээн авч байгаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, оюуны өмчийн үнэлгээг эрх бүхий үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн ТУЗ тогтооно.
- 5.9. Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлж болно. Шаардлагатай тохиолдолд хувь нийлүүлсэн хөрөнгөнд шинээр хөрөнгө оруулалт оруулж болно.
- 5.10. Компани тодорхой нөхцөлөөр хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно.

6. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

- 6.1. Компанийн хувьцааг худалдан авч эзэмшсэн этгээд Компанийн хувьцаа эзэмшигч байна.
- 6.2. Компаниас хууль тогтоомжийн дагуу ногдол ашиг хуваарилахаар зарлан мэдэгдсэний дагуу ногдол ашиг авах эрхтэй байна.
- 6.3. Давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон нөхцөлийн дагуу ногдол ашиг авах эрхтэй байна.
- 6.4. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах уед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшлийн саналын эрхтэй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх эрхтэй байна.
- 6.5. Дүрмийг 5.9 дэх хэсэгт запасал асуудал болон хувьцаа эзэмшигчдод хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн



хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

- 6.6. Хувьцаа эзэмшигч нь Компаниас нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй байна. Энэ давуу эрхийг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасан журмын дагуу хэрэгжүүлэх үүргийг ТУЗ хүлээнэ.
- 6.7. Саналын эрх бүхий энгийн хувьцааны тав буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш хуанлийн 60 хоногийн дотор ТУЗ эсхүл Гүйцэтгэх захиралд гаргаж болно. Санал хүргүүлсэн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 66.3 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангасан саналыг хүргүүлнэ.
- 6.8. Саналын эрх бүхий энгийн хувьцааны арван хувиас дээш хувийг эзэмшигч нь Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалтыг жилд нэг удаа тодорхой үндэслэл бүхий шаардлага гарган хийлгэх эрхтэй. Ийнхүү шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч шаардлагын дагуу шалгалт хийсэн аудиторын зардлыг хариуцна.
- 6.9. Компанийн энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь уг хяналтын багцыг худалдан авсан өдрөөс хойш ажлын 60 өдрийн дотор бусад хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн 6 сарын зах зээлийн үнийн жинлэсэн дунджаас доошгүй үнээр худалдан авахаар санал болгох үүрэгтэй байна.
- 6.10. Саналын эрх бүхий энгийн хувьцааны арав буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар ТУЗ-д санал шаардлага гаргах эрхтэй. Ийнхүү санал, шаардлага гаргаж буй хувьцаа эзэмшигч нь санал, шаардлагаа бичгээр гаргах буюу Компанийн тухай хуулийн 61.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.
- 6.11. Хувьцаа эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 6.12. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх эрхтэй байна.
- 6.13. Компанийн ТУЗ-ийн гишүүн эсхүл эрх бүхий албан тушаалтан, дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран Компанийн хувьцааны арваас дээш хувийг эзэмшдэг бөгөөд түүний буруутай үйл ажиллагааны улмаас Компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээд өөрийн хувийн эд хөрөнгөөр Компанийн өмнө хариуцна.
- 6.14. Давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 6.14.1. Давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг энгийн хувьцаа эзэмшигчдээс тэргүүн ээлжид авах;
 - 6.14.2. Компанийн тухай хуульд заасан асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал өгөх;



- 6.14.3. Компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хуримтлагдсан ногдол ашиг болон өөрийн эзэмшилийн хувьцааны татан буулгалтын үнийг авах;
- 6.14.4. Компанийг нийлуулэх, нэгтгэх, хуваах, эсхүл дүрэмд хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан нэмэлт, өөрчлөлт оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшилд байгаа давуу эрхийн хувьцаагаа компани эргүүлэн худалдаж авахыг шаардах;
- 6.14.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон хугацааны дараа давуу эрхийн хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшилд байгаа давуу эрхийн хувьцаагаа гэрээнд урьдчилан тогтоосон үнээр эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах.
- 6.15. Компанийн тухай хуульд заасны дагуу давуу эрхийн хувьцаа эзэмшигч дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцно. Үүнд:
- 6.15.1. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах болон компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлахдаа давуу эрхийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарласан заалтыг оруулж байгаа бол;
- 6.15.2. Компанийг өөрчлөн байгуулах явцад давуу эрхийн хувьцааг энгийн хувьцаа, бусад төрлийн үнэт цаас болон бусад хөрөнгөд хөрвүүлж байгаа бол.
- 6.16. Компанийн тухай хуульд заасны дагуу давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь давуу эрхийн хувьцааны ногдол ашгийг хугацаанд нь аваагүй тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл сонгох тухай Хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцно.
- 6.17. Энэхүү Дүрэмд тусгагдаагүй хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой бусад харилцааг Монгол Улсын холбогдох хучин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн актад заасны дагуу зохицуулна.

7. КОМПАНИ ҮНЭТ ЦААС ГАРГАХ, ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ

- 7.1. Компани нь гаргасан энгийн хувьцаанаас гадна давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг, хувьцаанд хамаарах үнэт цаас (*опцион, хувьцаанд хөрвөх үнэт цаас*) гаргаж болно.
- 7.2. Компанийн зарласан хувьцааг гүйлгээнд гаргах шийдвэрийг ТУЗ гаргана.
- 7.3. Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.
- 7.4. Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, тогтоосон хугацаанд худалдах, худалдан авах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно.
- 7.5. Компаниас гаргасан хувьцаанд хөрвөх үнэт цаасаар хөрвөх хувьцааны тоо, нийт гаргасан опционоор худалдах хувьцааны тоо, гүйлгээнд гаргасан хувьцааны тоо зэргийн нийлбэр нь нийт зарласан хувьцааны тооноос илүү байж болохгүй.
- 7.6. Хувьцаа болон бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 55-р зүйлд заасны дагуу ТУЗ тогтооно.
- 7.7. Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа хувьцааны төлбөр нь мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэртэй байж болно.
- 7.8. Компани оорийн гаргасан үицт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл



зарим хэсгийг худалдан авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны хорин таван хувиас хэтрэхгүй байна.

- 7.9. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдан авах шийдвэрийг Компанийн тухай хуулийн 53.2 дах хэсэгт зааснаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэрт худалдаж авах үнэт цаасны төрөл тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

8. КОМПАНИЙН УДИРДЛАГА

- 8.1. Компанийн эрх бүхий дээд байгууллага нь хувьцаа Эзэмшигчдийн хурал байна.
- 8.2. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.
- 8.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулна.
- 8.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргалах этгээд нь тухайн хурлыг хуралдуулах санал гаргасан этгээд байх бөгөөд түүнийг тухайн хурал хуралдуулах шийдвэрт тусгана.
- 8.5. Хувьцаа Эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй байна. Үүнд:
- 8.5.1. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулгыг батлах;
 - 8.5.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, буюу өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах;
 - 8.5.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;
 - 8.5.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх, ТУЗ-ийн өөрчлөн зохион байгуулах төслийг батлах, шийдвэр гаргах;
 - 8.5.5. Компанийг татан буулгах, татан буулгах комиссыг томилох;
 - 8.5.6. Компанийн хувьцааг хуваах, нэгтгэх;
 - 8.5.7. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
 - 8.5.8. Хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх шийдвэр гаргах;
 - 8.5.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 8.5.10. ТУЗ-өөс хэлэлцүүлэхээр оруулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
 - 8.5.11. Компанийн гаргасан энгийн хувьцааг буцаан худалдан авахыг зөвшөөрөх;
 - 8.5.12. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудлууд;
 - 8.5.13. Хууль тогтоомжийн актад заасан бусад.
- 8.6. Нэг хувьцаа нэг саналын эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийг сонгох саналын эрхийн тоог тогтоохдоо тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох нийт гишүүний тоогоор үржүүлж тодорхойлно.
- 8.7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах Дүрмийн 8.5.1-8.5.6 дах заалтуудад заасан асуудлыг саналын эрхтэй хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар, бусад асуудлыг холбогдох хууль



тогтоомжид өөрөөр заагаагүй бол саналын эрхтэй хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

- 8.8. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах тухай нийтэд зарлах, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр, санал авах ажиллагааг Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, мэдээ хүргэх журам”-ын дагуу зохицуулна.
- 8.9. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргаж, хурлаар хэлэлцэх асуудлыг тогтоосноос хойш ТУЗ, Гүйцэтгэх захирал, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар нэн даруй хэлэлцэж шийдвэрлэх асуудал гарсан тохиолдолд хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар уг асуудлыг хэлэлцэхээр шийдвэр гаргаж болно.
- 8.10. Компанийн саналын эрхтэй хувьцааны дийлэнх олонхийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно. Хэрэв хувьцаа эзэмшигчдийн хурал хүчин төгөлдөр болох хувь хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэж хурлыг хойшлуулж дахин хуралдах өдрийг товлож эн тухай тэмдэглэл үйлдэн ТУЗ-ийн Дарга гарын үсэг зурна. Тухайн хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг өөрчилж болохгүй.
- 8.11. Саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхи оролцсоноор Дүрмийн 8.10 дах хэсэгт заасан хойшлогдсон хурал хүчин төгөлдөр болно.
- 8.12. Дүрмийн 8.10 дах хэсэгт заасан хойшлогдсон хурлын бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй ба ажлын 20 өдрийн дотор дахин зарлан хуралдуулна. Хойшлогдсон хурал хуралдахаас хамгийн багадаа ажлын 5 өдрийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг дахин мэдээлнэ.
- 8.13. Дүрмийн 8.10 дах хэсэгт заасан хойшлогдсон хурал ажлын 20 өдрийн дотор хуралдаж чадаагүй тохиолдолд шинээр хурал товлон зарлаж хурал хүчин төгөлдөр болох ирцийг Дүрмийн 8.10 дах хэсэгт зааснаар тогтооно.
- 8.14. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэрлэж болно. Эчнээ санал хураалтыг Компанийн тухай хуульд заасны дагуу явуулна.
- 8.15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болон дараах асуудлыг шийдвэрлэх ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулахыг хориглоно.
 - 8.15.1. Компанийн үйл ажиллагааны чиглэлийг нэмэхээс бусад Дүрмийн нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг батлах;
 - 8.15.2. Компанийг өөрчлөн байгуулах, зохион байгуулалтын хэлбэрийг өөрчлөх.
- 8.16. Компанийн нийт гаргасан хувьцааны арваас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь өөрөө хүсвэл эчнээ санал хураалтын дүнг нэгтгэн гаргах тооллогын комиссын үйл ажиллагаанд ажиллагчаар оролцох эрхтэй байна.
- 8.17. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хөтөлж, баталгаажуулан хадгална.

9. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

- 9.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь эрх хэмжээнийхэс дагуу хамгийн цооцдоо улирал бүр хуралдана.
- 9.2. ТУЗ нь нийт 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 3 гишүүн нь хараат бус гишүүн байна.



- 9.3. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхийн саналаар ТУЗ-ийн дарга (цаашид “ТУЗ-ийн Дарга” гэх)-ыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос сонгоно.
- 9.4. ТУЗ-ийн гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар гурван жилийн хугацаатай сонгоно. ТУЗ-ийн гишүүдийг сонгоходоо санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ.
- 9.5. ТУЗ-өөс тогтоол гаргах бөгөөд түүнд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 9.6. ТУЗ нь хувьцаа Эзэмшигчийн бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 9.6.1. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийг тогтоох, өөрчлөх;
 - 9.6.2. Хувьцаа эзэмшигчийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах,
 - 9.6.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалт гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх;
 - 9.6.4. Компанийн зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
 - 9.6.5. Хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;
 - 9.6.6. Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
 - 9.6.7. Өөрийн гаргасан нийт энгийн хувьцааны тав хүртэлх хувийг болон бусад үнэт цаасыг худалдах, эргүүлэн авах шийдвэр гаргах;
 - 9.6.8. Компанийн Гүйцэтгэх Захирлыг сонгох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгох, тусгайлсан асуудлаар түүнд эрх олгох;
 - 9.6.9. Гүйцэтгэх Захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг батлах, өөрчлөлт оруулах, түүнд олгох, шагнал, урамшуулал, цалингийн хэмжээг тогтоох;
 - 9.6.10. Компанийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
 - 9.6.11. Компанийн тухайн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
 - 9.6.12. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, үйл ажиллагааны журмыг батлах;
 - 9.6.13. Нэмж гаргах хувьцаа нь их хэмжээний хэлцэлд хамаарах бол хувьцаа нэмж гаргах асуудлыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй шийдвэрлэх бөгөөд санал нэгдээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэх;
 - 9.6.14. Хараат болон охин компани, гадаад улс дахь салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн эрх хэмжээ, удирдлага, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох, гүйцэтгэх удирдлагыг томилох болон хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх;
 - 9.6.15. Компанийг өөрчлөн байгуулах төсөл боловсруулж хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх, шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;



- 9.6.16. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;
- 9.6.17. Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;
- 9.6.18. Компанийн стратегийн, дунд хугацааны, болон жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагааны бодлогыг батлах;
- 9.6.19. Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн системийг батлах;
- 9.6.20. Компанийн бүх төрлийн бодлогын болон засаглалын баримт бичгийг батлах;
- 9.6.21. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар шийдвэр гаргаж, ногдол ашгийн хэмжээ, хуваарилах журам, бодлого тодорхойлох;
- 9.6.22. ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүдийг томилох тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон үйл ажиллагааны журмыг батлах;
- 9.6.23. Компанийн жилийн бизнес төлөвлөгөөг батлах үед тодорхойлох боломжгүй байсан 1,500,000,000 (Нэг тэрбум таван зуун сая) төгрөгөөс дээш зах зээлийн үнэтэй үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, барьцаалах, барьцаалуулах болон бусад хэлбэрээр захиран зарцуулахтай холбоотой гэрээ байгуулах зөвшөөрөл олгох
- 9.6.24. Компанийн тухай хууль болон энэхүү дүрмээр тогтоосон бусад асуудал;
- 9.6.25. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.
- 9.7. ТУЗ-ийн Дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, ТУЗ-ийн хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих зэрэг Компанийн тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 9.8. ТУЗ нь ТУЗ-ийн Нарийн бичгийн даргатай байх бөгөөд түүнийг ТУЗ-ийн Дарга томилно.
- 9.9. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
- 9.10. ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн хуралд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд бүх төрлийн цахим болон утсан холбооны хэрэгсэл ашиглан хуралд оролцож хэлэлцэх асуудлаар санал өгөх болон эчнээ санал хураалтаар санал өгч шийдвэр гаргаж болно.
- 9.11. Компанийн тухай хуулийн 96.4 дэх хэсэгт заасан тайланг бэлтгэж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.
- 9.12. ТУЗ болон түүний дэргэдэх хороод нь батлагдсан үйл ажиллагааны журмын дагуу үйл ажиллагаа эрхлэн явуулна.
- 9.13. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хуулийн 75.8, 79.1 дэх хэсэгт заасан шалгуур, шаардлагыг хангасан байна.
- 9.14. ТУЗ-ийн аль нэг гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан эсхүл нас барсан тохиолдолд түүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль явуулах хүртэл ТУЗ-өөс түр томилно.
- 9.15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй тохиолдојд ТУЗ-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрх дуусгавар болно.




- 9.16. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр ТУЗ-ийн бүрэн эрх, бүрэн бүрэлдэхүүнийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.
- 9.17. ТУЗ түүний хурлын бүрэн эрх, хуралтай холбоотой бусад асуудлыг Компанийн тухай хууль болон “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-д заасны дагуу зохицуулна.

10. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРОО

- 10.1. ТУЗ нь байнгын үйл ажиллагаатай Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороо, Эрсдэлийн удирдлага, Тогтвортой байдлын хороодтой байна.
- 10.2. ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог Компанийн тухай хуулийн 81-р зүйлд заасны дагуу байгуулж болно.
- 10.3. ТУЗ нь хороодын бүтэц, бүрэлдэхүүнийг Компанийн тухай хуулийн 81.2 дах хэсэгт заасны дагуу томилно.
- 10.4. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд тухайн асуудлаар дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, Компанийн тухай хууль болон энэхүү Дүрэмд заасан асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна.
- 10.5. ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх хэмжээ болон үйл ажиллагааны журмыг ТУЗ батална.

11. ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, ТҮҮНИЙ ЭРХ ХЭМЖЭЭ

- 11.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-ийн сонгосон Гүйцэтгэх Захирал (цаашид “Гүйцэтгэх Захирал” гэх) хэрэгжүүлэх ба Гүйцэтгэх захирал нь Дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 11.2. Гүйцэтгэх Захирал нь Компанийг төлөөлж энэхүү Дүрэмд заасан өдөр тутмын үйл ажиллагааг тусгайлсан итгэмжлэлгүйгээр хэрэгжүүлнэ.
- 11.3. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.
- 11.4. Гүйцэтгэх Захирал нь өөрт олгогдсон бүрэн эрхээ зохистой үйл ажиллагаанд хэрэгжүүлэх ба энэхүү Дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээтэй зөрчилдөх хэлбэрээр ажиллажыг хориглоно. Гүйцэтгэх Захирал нь өөрийн эрх, үүргийг хэрэгжүүлэхдээ үнэнч шударга байж Компанийн эрх, ашиг сонирхлыг тэргүүнд тавьж ажиллана.
- 11.5. Гүйцэтгэх Захирал нь дор дурдсан эрх хэмжээтэй байна. Үүнд:
 - 11.5.1. Компанийн стратегийн бодлого, дунд хугацааны болон жилийн бизнес төлөвлөгөө, төсвийг Компанийн зорилго, зорилтод нийцүүлэн боловсруулж ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах;
 - 11.5.2. Компанийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн систем зэргийг батлагдсан хүрээнд удирдан, зохион байгуулах, тэдгээртэй холбоотой шийдвэр гаргах;
 - 11.5.3. Компанийн үйл ажиллагааг тухайн жилийн батлагдсан бизнес төлөвлөгөө, төсвийн хүрээнд эрхлэн явуулах, захирлан зарцуулах;
 - 11.5.4. Компанийн жилийн бизнес төлөвлөгөөг батлах үед тодорхойлох боломжгүй байсан эсхүл ТУЗ-өөс тусгайлан тогтоосон эрхэд хамаарахгүй 1,500,000,000 (Нэг тэрбум таван зуун сая) төгрөг хүртэлх зах зээлийн үнэтэй үл хөдлөх болои ходлох эд хороогийн эрхийг худалдах, худалдаа авах, барьцаалах, барьцаалуулах болон бусад хэлбэрээр захирлан зарцуулахтай холбоотой гэрээ хэлцэл бие даан байгуулах, уг эрхээ өөр этгээдэд итгэмжлэлээр олгох



- 11.5.5. Зээлийн хорооны гишүүдийг томилох, чөлөөлөх;
- 11.5.6. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой дотоод журам, дурэм заавар батлан мөрдүүлэх;
- 11.5.7. Хувьцаа эзэмшигч болон ТУЗ-өөс шаардсан тайлан, мэдээлэл, баримт бичгийг тухай бүр бэлтгэн гаргаж өгөх;
- 11.5.8. Компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн шүүхийн маргаан, өр барагдуулах үйл ажиллагаа, хэрэг хянан шийдвэрлэх болон захиргааны журмаар шийдвэрлүүлэх аливаа ажиллагаанд Компанийг төлөөлөн оролцож, асуудлыг шийдвэрлэх, энэ талаар өмгөөлөгч болон бусад тусгайлан эрх авсан холбогдох этгээдүүдтэй гэрээ байгуулах, Компанийг төлөөлөх этгээдэд итгэмжлэл олгох, эрх ашгийг хамгаалах холбогдох арга хэмжээг авах;
- 11.5.9. Компанийн үндсэн болон гэрээт ажиллагдыг ажилд авах, чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ болон бусад төрлийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох, тэдгээрийн ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, урамшуулах, Хөдөлмөрийн тухай хууль болон Компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажилтанд хөдөлмөрийн сахилгын арга хэмжээ авах, холбогдох гэрээний дагуу хариуцлага тооцох;
- 11.5.10. Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарахаас бусад Компанийн эрх бүхий албан тушаалтныг томилох, Монгол улс дахь салбар, төлөөлөгчийн газар байгуулах, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох, түүний гүйцэтгэх удирдлагыг бие даан томилох, чөлөөлөх, бүрэн эрх хэмжээг тогтоох, ажлын байрны тодорхойлолтыг батлах, шаардлагатай тохиолдолд хугацаанаас нь өмнө чөлөөлөх, тэдгээрийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх.
- 11.6. Гүйцэтгэх Захирал нь дор дурдсан үүргийг хүлээнэ. Үүнд:
- 11.6.1. Компанийн дүрэм, Хувьцаа Эзэмшигчийн хурал, ТУЗ-өөс баталсан бодлогын баримт бичигт заасан үүргийг биелүүлж, Компанийн ашиг сонирхлын төлөө үнэнч шударгаар ажиллах;
- 11.6.2. Компанийн үйл ажиллагааг Монгол Улсын хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн акт, Банк бус санхүүгийн байгууллагад холбогдох хууль, тогтоомж, журам болон Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банкны шаардлагад бүрэн нийцүүлж ажиллах;
- 11.6.3. Хувьцаа Эзэмшигч болон ТУЗ-ийн шийдвэр, тогтоол, Компанийн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах;
- 11.6.4. Санхүүгийн тайлан бүртгэлийг холбогдох хууль, тогтоомж, заавар, журмын дагуу үнэн зөв гаргуулах;
- 11.6.5. Хөлсөөр ажиллах гэрээгээр тогтоосон үүргийг биелүүлэх.
- 11.7. Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр Компанийн нэгдлийн оролцогчид хамаарахгүй этгээдийн гүйцэтгэх удирдлагаар ажиллахыг хориглоно.
- 11.8. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас, Компанид учруулсан эд хөрөнгийн хохирлыг өөрийн хөрөнгөөр Компанийн өмнө хариуцна.
- 11.9. Гүйцэтгэх захирал нь бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргана.

12. КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

- 12.1. ТУЗ нь Гүйцэтгэх Захирлын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.



- 12.2. Компанийн ТУЗ-өөс хэрэгжүүлэх хяналтад дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:
 - 12.2.1. Гүйцэтгэх Захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилт;
 - 12.2.2. Компанийн ТУЗ-ийн баталсан Компанийн стратеги, дунд болон жилийн бизнес төлөвлөгөө, төсвийн биелэлт;
 - 12.2.3. Компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны төлөвлөгөөний биелэлт, бүрдүүлэлт;
 - 12.2.4. Компанийн өмч хөрөнгийг захирлан зарцуулах талаар тогтоосон Гүйцэтгэх Захирлын эрх хэмжээний хэрэгжилт;
 - 12.2.5. Компанийн хувьцаа Эзэмшигч болон ТУЗ-ийн гаргасан шийдвэр, тогтоолын хэрэгжилт.
- 12.3. Дотоод хяналтын үйл ажиллагааны журмыг ТУЗ-ийн хурлаас батална.
- 12.4. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудиторын шалгалт нь ээлжит бус байна. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.
- 12.5. Ээлжит бус шалгалтыг ТУЗ-ийн шийдвэр, Компанийн энгийн хувьцааны арван хувиас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирлын шийдвэрээр хэдий ч хийж болно. Аль нэг хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэнээс бусад шалгалтын хөлсийг Компани хариуцан төлнө. Хувьцаа эзэмшигчийн захиалгаар хийгдсэн шалгалтын хөлсийг тухайн хувьцаа эзэмшигч хариуцаж төлөх бөгөөд шалгалтын явцад эрх бүхий албан тушаалтан эсхүл хувьцаа эзэмшигч хуулийн этгээд, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.
- 12.6. Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг холбогдох дотоод журам болон холбогдох хууль тогтоомжийн актад заасны дагуу Компанийн дотоод хяналт хариуцсан ажилтан хяналт тавьж ажиллана.

13. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮРТГЭЛ ТАЙЛАН, НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТ

- 13.1. Компанийн санхүүгийн жил нь 1 дүгээр сарын 1-ний өдрөөс (эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс) эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр (сүүлийн жилийн хувьд Компанийн үйл ажиллагааг зогсоосон өдөр) дуусна.
- 13.2. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар болон бусад албан татвар, гаалийн хураамж, газрын төлбөр болон бусад төлбөр хураамжийг төлнө.
- 13.3. Компани нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж болон нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журмын дагуу саижүү, пягтлап бодох бүртгэлээ хөтөлж холбогдох тайлан, балансыг татвар, санхүүгийн байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хууль тогтоомжид заасан хугацаанд хүргүүлнэ.
- 13.4. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Гүйцэтгэх Захирал хариуцна. Компанийн орон тоонд хөдөлмерийн гэрээгээр ажиллаж байгаа Ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.
- 13.5. Компани нь Санхүү аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл тайлан тэнцэл, татварын тооцооллын үнэн зөв магадлал, хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулах туслалцаа авч байна.



- 13.6. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд энгийн хувьцаа эзэмшигчид цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна.
- 13.6.1. Ногдол ашиг хуваарилсны дараа Компани төлбөрийн чадвартай байх;
 - 13.6.2. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;
 - 13.6.3. Ногдол ашиг хуваарилсны дараа Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаалсны өмнөх хэмжээнээс 25-аас илүү хувиар багассан тохиолдолд ногдол ашгаа шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчдэдээ Хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үргийг Гүйцэтгэх Захирал хэрэгжүүлнэ.
 - 13.6.4. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх болон нийгэмд хандсан арга хэмжээ зохион байгуулах, сан байгуулж болно. Санг байгуулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. Уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг Гүйцэтгэх Захирал боловсруулан ТУЗ-д танилцуулж, батлуулж мөрдөнө.
- 13.7. Компани нь жил бүр давуу эрхийн хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилах бөгөөд энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаас тэргүүн ээлжиннд тухайн жилийн ногдол ашгийг дараа жилийн 4 сарын 30-ны өдрийн дотор олгоно.
- 13.8. Давуу эрхийн хувьцаа эзэмшигчид хуваарилах ногдол ашгийн хэмжээг эзэмшиж буй давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнийн дунгээс тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрийн Монгол банкны бодлогын хүү дээр 5 (тав) хувь нэмж тооцон тодорхойлно.
- 13.9. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ нь энэ тухай шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.
- 13.10. ТУЗ нь Ногдол ашиг хуваарилах болон түүнтэй холбоотой бусад харилцааг Компанийн Ногдол ашгийн бодлогод заасны дагуу зохицуулна.

14. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

- 14.1. Компанийн ТУЗ-ийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх Захирал, Тэргүүн дэд захирал, хариуцсан захирлууд (C level), Ерөнхий нягтлан бодогч, Газрын захирлууд болон Зээлийн хорооны гишүүд нь Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцогдоно.
- 14.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, ажилтантай байгуулсан гэрээ, холбогдох бусад журамд заасан эрхийг эдэлж, үргийг хүлээнэ.
- 14.3. Компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь томилогдсоноос хойш ажлын 10 одрийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж ТУЗ-ийн Нарийн бичгийн даргад өгөх ба уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүр уг мэдээллийг Компанид мэдэгдэнэ. Нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт гаргах зааврыг ТУЗ батална.

15. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ, ӨР ТӨЛВОРИЙГ БАРАГДУУЛАХ

- 15.1. Компанийн тухай хуульд зааснаар Компанийг хуваах, тусгаарлах, болон өөр хуулийн этгээдэд нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулж болно.



- 15.2. Компанийг хувьцаа Эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгаж болно.
- 15.3. Хувьцаа Эзэмшигчдийн хурал нь татан буулгах комиссыг томилно.
- 15.4. Татан буулгах комисс томилсноор тухайн Компанийн бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжинэ.
- 15.5. Татан буулгах комисс нь татан буулгах ажлыг бүрэн гүйцэтгэсний дараа тайлан гаргана.
- 15.6. Татан буулгах комиссоос зээлдүүлэгчийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгө нь Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгогдоно.
- 15.7. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуульд заасны дагуу ажиллан, Компанийг улсын бүртгэлийн байгууллагын улсын бүртгэлээс хасалт хийлгэнээр татан буугдах ажиллагаа дуусгавар болгоно.
- 15.8. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас Компанид ямар нэг хохирол учруулсан бол уг хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцан арилгана.
- 15.9. Компанийг татан буулгах тохиолдолд давуу эрхийн хувьцаа эзэмшигчид төлөх төлбөр, түүнийг төлөх журам, дэс дарааллыг холбогдох хууль тогтоомж болон Компанийн шийдвэрийн дагуу зохицуулах бөгөөд энгийн хувьцаа эзэмшигчдээс тэргүүн ээлжинд давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд татан буулгалтын үнийг олгоно.

16. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 16.1. Энэхүү Дүрэм, Компанийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн хувьцаа эзэмшигчдийн хурал шийдвэрлэж чадаагүй, эсхүл тухайн шийдвэрийг эс зөвшөөрсөнтэй холбоотой аливаа маргааныг гагцхүү шүүхээр шийдвэрлүүлнэ.

17. БУСАД ЗҮЙЛ

- 17.1. Компани нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандaa Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль, тогтоомж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржээс баталсан холбогдох заавар, журмыг мөрдэн ажиллана.
- 17.2. Энэхүү Дүрэм нь бүртгэх байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

